

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... өдөр

Улаанбаатар
хот

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдахаас өмнө Монгол Улсын Хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.7 дахь хэсэгт заасан хувь хэмжээгээр мөнгөн урамшуулал авсан цэргийн алба хаагчид Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.22 дахь заалтад заасны дагуу мөнгөн урамшууллыг үргэлжлүүлэн олгохдоо тухайн алба хаагчийн хамгийн сүүлд мөнгөн урамшуулал авсан хугацааг харгалзан тооцож олгоно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг